

*Мал аж ахуйн тогтвортой
үйлдвэрлэл эрхэлж, байгалийн
тэнцвэрт байдлыг хадгалах*



ТОГТВОРТОЙ НОЛУУРЫН БАТАЛГАА

Бид ноолуураа тогтвортой ноолуурын 25 шалгуур болон түүхий эд ангиллын батлагдсан схемийн дагуу бэлтгэдэг бөгөөд хоршооны гишүүд нь Тогтвортой ноолуур гэрчилгээтэй. Ноолуурын баталгааг шалгах гадны болон дотоод хяналттай. Дотоод хяналтыг хоршооны Бүлэг хариуцсан малчин нь шалгууруудын дагуухийж, онооны үнэлгээ өгдөг бол Гэрчилгээг аймгийн болон үндэсний хэмжээний Гэрчилгээжүүлэлтийн хороо баталгаажуулж, олгодог.

“ТОГТВОРТОЙ НОЛУУР” ХОЛБОО

“Тогтвортой ноолуур” холбоо нь AVSF Монгол буюу Хил хязгааргүй малын эмч нар ба агрономичид байгууллагын дэмжлэгтэйгээр тогтвортой ноолуур бэлтгэгч хоршоодын санаачилгаар байгуулагдсан бөгөөд ашгийн бус, гишүүдэд үйлчилдэг төрийн бус байгууллага юм. Өнөөгийн байдлаар “Тогтвортой ноолуур” Холбоо нь Баянхонгор аймгийн таван хоршооны 350 орчим өрхийн 1600 гаруй малчинтай.



ХОЛБОО БАРИХ:

Хоршооны дарга
Д. Баттоогоо +976 91613993

Хоршооны Гүйцэтгэх захирал
Ц. Дэмбэрэл +976 96759577



ОРОГ НУУРЫН ХИШИГ ХОРШОО

БОГД СУМ,
БАЯНХОНГОР АЙМАГ





ХОРШООНЫ ТАНИЛЦУУЛГА

“Орог нуурын хишиг” Хоршоо нь анх 2016 онд 7 сард 37 гишүүнтэй байгуулагдаж, өдгөө бэлчээр ашиглагчдын гурван хэсгийг хамруулан 46 гишүүнтэй болж өргөжөөд байна. Хоршоо нь Хөдөө аж ахуйн хоршоологчдын холбоо болон “Тогтвортой ноолуур” Холбооны гишүүн бөгөөд гишүүдийн 90 гаруй хувь нь Тогтвортой ноолуур Гэрчилгээтэй. Хоршоо нь дарга, нягтлан бодогч, техникч малчин, тэргүүлэгч, хяналтын зөвлөлийн гишүүдтэй бөгөөд цагаан ямаагаар цөм сүргээ бүрдүүлсэн.



ХОРШООНЫ ЗОРИЛГО

Манай хоршооны зорилго мал аж ахуйн тогтвортой үйлдвэрлэл эрхэлж, байгалийн тэнцвэрт байдал хадгалж, гишүүдийнхээ амьжиргааг дэмжихийн зэрэгцээ бэлчээрийн зөв зохистой менежментийг хэрэгжүүлэхэд оршино.



ХОРШООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

“Орог нуурын хишиг” хоршоо нь малынхаа түүхий эд буюу ноолуурыг байгальд ээлтэй, хоршооны гишүүдэд тэгш хүртээмжтэй, эдийн засгийн шударга хуваарилалттай аргаар бэлтгэн, “Тогтвортой ноолуур” холбоогоор дамжуулан нэмүү өртгөөр борлуулдаг юм.

Манай хоршоо гишүүдийнхээ эрүүл мэндэд анхаарч эмчийн үзлэгт хамруулж, нэг га газрыг хашиж хамгаалахад шаардлагатай эд материалаар дэмжлэг үзүүлсэн. Түүнчлэн хоршооны гишүүд ноолуур ангилан ялгах, өрхийн аж ахуй төлөвлөлтийн сургалтуудад хамрагдаж, сумын байгаль орчны байцаагчтай хамтран бэлчээрийн мониторинг хийж, арга хэмжээнд идэвхтэй оролцдог.

ЦААШДЫН ЗОРИЛТ

Бид цаашид гишүүнчлэл болон ноолуурынхаа хэмжээг нэмэгдүүлэхийн зэрэгцээ бэлчээрийн менежментийг сайжруулах чиглэлд түлхүү анхааран ажиллана. Мөн захиалагчдынхаа итгэлийг дааж, гэрчилгээжсэн тогтвортой ноолуурыг тогтмол баталгаатай нийлүүлж, аймаг, нутгийнхаа нэр болон улаан ямааны ноолуурын үнэ цэнийг нэмэгдүүлж, удмын санг нь хадгалж, дотоод, гадаадын хэрэглэгчдэд таниулахад хувь нэмрээ оруулах зорилго тавьж байна.

